



ХҮҮХЭД СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Хүүхдийн анагаахын эмнэлзүйн чиглэлээр жил бүр 4 багц цагийн сургалтад хамрагдсан байх;
2. Хүүхдийн эмнэлзүйн анагаах ухааны чиглэлээр илтгэл, өгүүлэл хэвлүүлсэн байх (3 цөөнгүй байх);
 - "Монголын хүүхдийн анагаах ухаан" сэтгүүлд эмнэлзүйн тохиолдол, илтгэл өгүүлэл /нэгдүгээр, хамтран зохиогч байж болно/ онолын лекц хэвлүүлэх.
3. Хүүхдийн анагаахын салбарын бусад мэргэжилтнүүдтэй албан ёсоор хамтран ажиллан, туршлагаа солилцдог байх; Үүнд:
 - Хүүхдийн эмч нарын улсын зөвлөгөөнд оролцох
 - Хүүхдийн эмч нарын эрдэм шинжилгээний хуралд оролцох

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Хүүхдийн анагаахын эмнэлзүйн чиглэлээр жил бүр 4 багц цагийн сургалтад хамрагдсан байх;
2. Хүүхдийн анагаахын эмнэлзүйн чиглэлээр сүүлийн 3 жилд гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлсэн байх;
3. Сүүлийн 5 жилд хүүхдийн эмнэлзүйн анагаах ухааны чиглэлээр 3 ба түүнээс олон бүтээл /Үүнээс 2 нь нэгдүгээр зохиогчоор/ хэвлүүлсэн байх; Үүнд:
 - "Монголын хүүхдийн анагаах ухаан" ба бусад улсын сэтгүүлд өгүүлэл, эмнэлзүйн тохиолдол, онолын лекц орно.
4. Хүүхдийн анагаахын салбарын бусад мэргэжилтнүүдтэй албан ёсоор хамтран ажиллаж, туршлагаа солилцдог байх; Үүнд:
 - Хүүхдийн эмч нарын улсын зөвлөгөөнд оролцох, орон нутаг, бүсийн чанартай зөвлөгөөн зохион байгуулах
 - Хүүхдийн эмч нарын эрдэм шинжилгээний хуралд оролцох

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Хүүхдийн анагаахын эмнэлзүйн чиглэлээр жил бүр 4-5 багц цагийн сургалтанд хамрагдсан байх;
2. Анагаахын шинжлэх ухааны магистр (диссертаци, авторефератын эх хувь), Анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан байх; (**Хөдөө орон нутагт хүүхдийн эмчээр 25 ба түүнээс дээш жил үр дүнтэй, тасралтгүй ажилласан тохиолдолд комиссын шийдвэрээр оруулж болно**)
3. Улс, үндэсний хэмжээний дотоодын ба гадаадын мэргэжил дээшлүүлэх урт ба богино хугацааны сургалтанд 5 жилд 2-оос доошгүй удаа хамрагдсан эсвэл мэргэшлийн чиглэлээр хуралд оролцсон байх;
4. Сүүлийн 5 жилд хүүхдийн эмнэлзүйн анагаах ухааны чиглэлээр жил бүр бүтээл /Үүнээс 3 нь нэгдүгээр зохиогчоор/ хэвлүүлсэн байх; "Монголын хүүхдийн анагаах ухаан" ба мэргэжлийн бусад сэтгүүлд эмнэлзүйн тохиолдол, онолын лекц, өгүүлэл хэвлүүлэх
5. Хүүхэд судлалын чиглэлээр сурах бичиг, гарын авлага бичих, мэргэшил арга зүйн чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулахад оролцсон байх;
6. Хүүхдийн анагаахын салбарын бусад мэргэжилтнүүдтэй албан ёсоор хамтран ажиллан, туршлага солилцдог байх. Үүнд:
 - Орон нутаг, нийслэл, дүүрэг, бүсийн чанартай эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнийг хүүхдийн эмч нарын дунд зохион байгуулах